

ЭМЭГТЭЙ БИЗНЕС ЭРХЛЭГЧ



In partnership with
Canada



The Asia Foundation



Мэдээллийн товхимол

2023 ОН - ДУГААР 4



ЭМЭГТЭЙ БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН “WOMEN OWNED” ТОХИРЛЫН ТЭМДЭГТ

Дэлхий дахинд олон улс орнууд “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүд” гэх нэр томъёог хуульчлан эмэгтэй бизнес эрхлэгчдэд анхаарал хандуулж байна. Монгол Улсад эмэгтэй бизнес эрхлэгч гэж хэн бэ гэдгийг хуулиар тодорхойлох “Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл өргөн баригдаад буй.

Харин бизнесийн зах зээлд Голомт банк болон Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим хамтран “Women Owned” тохирлын тэмдэгийг нэвтрүүлжээ. Энэхүү тэмдгийг олгож эхэлснээр бизнесийн зах зээлд эмэгтэй бизнес эрхлэгчдийг тодорхойлох, таних замаар тухайн бизнесийн борлуулалтыг нэмэгдүүлэх, эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжсэн төсөл хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулах боломж бүрдэж байна.



**“Women Owned” тохирлын тэмдэгт
ашиглах хүсэлт илгээх**

АЗИЙН САН БИЗНЕС ЭРХЛЭГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДЭД ЗОРИУЛСАН БӨӨНИЙ ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТИЙН B2B ПЛАТФОРМЫГ ХӨГЖҮҮЛЖ БАЙНА.

Азийн сан нь Give2Asia, Lotus Circle Funds-ийн санхүүжилтээр Гэрэгэ Системстэй хамтран хөгжүүлж буй нийлүүлэлтийн нэгдсэн B2B платформыг бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд танилцууллаа.

Энэхүү B2B платформ нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн нийлүүлэлтийн сүлжээ, бөөний худалдааг дэмжих, маркетинг үүсгэх, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд шаардлагатай сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг хүргэх, дижитал боловсрол олгох, B2B бөөний худалдан авалтыг нэг дороос хийх боломжуудыг бий болгох ажээ.

Уг платформын зорилго нь Монгол Улсын нийслэл хот болон хөдөө орон нутгуудад үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг холбох, сүлжээ байгуулах, дэмжлэг авах, эмэгтэйчүүдэд ханган нийлүүлэлтийн сүлжээг сурталчлах зорилгоор хүртээмжтэй, хялбар онлайн платформыг хөгжүүлэхэд орших бөгөөд урт хугацаанд төлбөрийн нэгдсэн систем, санхүүжилтийн боломжуудтай холбоход оршино.

B2B ПЛАТФОРМ



01

Бизнесээс бизнес
хамтын ажиллагаа

02

Онлайн худалдаа



03

Сургалт, зөвлөгөө

04

Нэгдсэн хянах систем



БАЙГУУЛЛАГА

Үйлчилгээгээ үзүүлэх байгууллага, мэргэжилтэн болон хэрэглэгч нарт үйлчилгээгээ хүргэх

1. B2B орчинг сайжруулахад нэн шаардлагатай үйлчилгээ үзүүлэх байгууллагууд мэргэжилтнүүдэд үйлчилгээгээ үзүүлэх орчинг бүрдүүлэх
2. Хамтран худалдан авалтад оролцох боломжийг эрэлхийлж буй бизнесүүдэд зориулсан булан



Хамтран ажиллагч байгууллагууд



Дэмжигч байгууллагууд



Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпын гудамж, 1-р хороо, Аюуд тээвэр, 12 давхар

(976)-7777-3773 info@gerege.mn



www.b2b.wbc.mn

B2B ПЛАТФОРМ

Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТТАЙ БИЗНЕСИЙН НОГООН ЗЭЭЛ

Энэхүү зээл нь ногоон бизнесийг дэмжих замаар барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг, дунд бизнес эрхлэгчдэд бизнесээ өргөжүүлэх, шинэ төсөл хэрэгжүүлэх боломжийг олгох, ногоон эдийн засгийг дэмжих зорилготой.

Зээлийн хэмжээ: 2 тэрбум хүртэл

Батлан даалтын хэмжээ: 1.2 тэрбум хүртэл

Зээлийн хугацаа: 9 хүртэлх жил

ЗБДС-ийн батлан даалтын хувь: 60%

Зээлийн хүү: 10.0% /жилийн/

Тавигдах шаардлага: ХХБ-ны “Тогтвортой санхүүжилтийн хамрах хүрээ”-д багтсан төсөл, хөтөлбөрүүд болон ЗБДС-ын хориглох жагсаалтад багтаагүй төсөл хөтөлбөр байх

Дэлгэрэнгүй мэдээлэл авах



ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТТАЙ
БИЗНЕСИЙН НОГООН ЗЭЭЛ

Эдийн засгийн бодлого,
өрсөлдөх чадварын судалгааны төв
“Макро эдийн засгийн тойм” 2023/10 сар



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ
2023/10

ДНБ-ий хэмжээ 6.9 хувь өсөв

2023 оны 3-р улиралд ДНБ-ий хэмжээ оны үнээр 46.5 их наяд төгрөгт хүрч, 6.9 хувиар өслөө. Үүнд Уул уурхай олборлолтын салбар 28.6 хувь, тээвэр агуулахын үйл ажиллагааны салбар 66.4 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.

Дэлгэрэнгүй унших

<p>ДНБ 6.9% 2023 оны 3-р улирал</p>	<p>ИНФЛЯЦ 9.0 Өмнөх сараас: 0,3 нэгж хувиар өсөж Оны эхнээс: 6.7 нэгж хувиар өсөв</p>	<p>\$</p> <p>ТӨГРӨГИЙН АМ.ДОЛЛАРТАЙ ХАРЬЦАХ ХАНШ 3,452.50 төг</p>
<p>ТӨСВИЙН ТЭНЦЭЛ 2062 тэрбум төгрөг</p>	<p>ГАДААД ХУДАЛДАА ТЭНЦЭЛ 4914 сая ам.доллар</p>	<p>ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ 3.9 тэрбум ам.доллар</p>
<p>ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ 8.29%</p>	<p>НҮҮРСНИЙ ЭКСПОРТ 52.0 сая тонн</p>	<p>МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨР 33.56 тэрбум ам.доллар</p>

Макро үзүүлэлт	Хэмжих нэгж	2023.X	2022.X	2023.IX	Өмнөх сараас	Өмнөх улирлаас	Оны эхнээс	Өнгөрсөн жилийн мөн үеэс
ДНБ 2023 оны 3-р улирал	их наяд ₮, оны үнээр	46.5	35.2	46.5	-	-	-	6.9% ▲
Инфляц	хувь	9.0	14.5	10.1	0.3% ▲	-	6.7% ▲	-5.5 нэгж хувиар ▼
Ажилгүйдлийн түвшин, 2023УЗ	хувь	5.2% 2023 оны УЗ	5.4% 2022 оны У2	5.8% 2023 оны У2	-	-0.6% ▼ нэгж хувиар	-	-0.2% ▼ нэгж хувиар
Төсвийн тэнцэл	тэрбум ₮, өссөн дүнгээр	2062	-1019	2158	-96 ▼	-	-	3080 ▲
Ам.долларын ханш	төгрөг	3452.50	3369.90	3466.08	-13.58 ▼	-	-	82.6 ▲
Гадаад худалдааны тэнцэл	сая ам.доллар, өссөн дүнгээр	4914.4	2864	4540.7	374 ▲	-	-	2051 ▲
Нүүрсний экспорт	сая тонн, өссөн дүнгээр	52	23.1	48.9	-51% ▼	-	-	2.2 дахин ▲
Зэсийн экспорт	мян.тонн, өссөн дүнгээр	1272	1093.4	1200	-6% ▼	-	-	6% ▲
Төв банкны бодлогын хүү	хувь	13%	12%	13%	0%	-	0%	1% ▲
Гадаад валютын нөөц	тэрбум ам.доллар	3.9	2.8	4.1	-4% ▼	-	-	43% ▲
Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь	хувь	8.29%	11.65%	8.43%	-0.14 нэгж хувиар ▼	-	-	-3.36 нэгж хувиар ▼